

ТӨВ БАНКНЫ РЕПО САНХҮҮЖИЛТИЙН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэ журмын зорилго нь Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1, 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, 13 дугаар зүйл, 14 дүгээр зүйлийг тус тус үндэслэн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, мөнгөний зах дахь мөнгөн хөрөнгийн нөөцийн илүүдэл, дутагдлыг зохицуулах, банк хоорондын захын хүүг зорилтот түвшинд хүргэх зорилгоор Монголбанкнаас банкинд олгох репо санхүүжилтийн харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэ журамд заасан дараах нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно:
 - 1.2.1 “Төв банкны репо санхүүжилт” гэж банк эзэмшиж буй үнэт цаасаа тохиролцсон хугацааны эцэст урьдчилан тохиролцсон үнээр буцаан худалдан авах нөхцөлтэй Монголбанкнаас ашиглах санхүүгийн байнгын хэрэгслийг;
 - 1.2.2 “Төв банкны овернайт репо санхүүжилт” гэж Монголбанкнаас банкинд “Банксүлжээ” систем хаахаас дараагийн ажлын өдрийн “Банксүлжээ” систем нээх хүртэл хугацаатай олгож буй нэг хоногийн хугацаатай Төв банкны репо санхүүжилтийг;
 - 1.2.3 “Худалдах үнэ” гэж репо хэлцлээр үнэт цаасаа худалдаж буй банкинд Монголбанкнаас төлж буй үнийн дүнг;
 - 1.2.4 “Репо санхүүжилтийн хүү” гэж үнийн зөрүүг тооцоход ашиглах Монголбанкнаас тогтоосон хүүгийн хувь хэмжээг;
 - 1.2.5 “Буцаан худалдан авах үнэ” гэж энэ журмын 1.2.3-т заасан худалдах үнэ дээр үнийн зөрүүг нэмсэн дүнг;
 - 1.2.6 “Үнийн зөрүү” гэж үнэт цаасыг худалдах үнээс 1.2.4-т заасан хүү болон репо санхүүжилтийг ашигласан хугацаагаар тооцсон дүнг;
 - 1.2.7 “Купонтой үнэт цаас” гэж хүүгийн тогтмол төлбөр нь үнэт цаасны хугацаа дуустал хоёр талын тохиролцсон хугацааны үе бүрт төлөгддөг үнэт цаасыг.
- 1.3 Энэ журмаар зохицуулаагүй репо санхүүжилтийн хэлцэлтэй холбоотой бусад нөхцөл, талуудын эрх үүргийг талуудын хооронд байгуулсан ерөнхий гэрээгээр зохицуулна.

Хоёр. Репо санхүүжилтийн нөхцөл

- 2.1 Репо хэлцэл нь овернайт буюу “Банксүлжээ” систем хаахаас дараагийн ажлын өдрийн “Банксүлжээ” систем нээх хүртэл хугацаатай байна.
/Энэ заалтад МБЕ-ийн 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А-281 дүгээр тушаалаар өөрчлөлт оруулсан/
- 2.2 Репо санхүүжилтийн хэлцлээр Монголбанкны худалдан авах үнэт цаасны жагсаалтыг Монголбанкны эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа хариуцсан нэгжээс тодорхойлон гаргаж, Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батална.

Гурав. Репо санхүүжилтийн үндсэн зарчим

- 3.1 Монголбанкнаас овернайт репо санхүүжилт олгох гүйлгээ нь банкны тухайн өдрийн хамгийн сүүлийн гүйлгээ, харин буцаан төлөх гүйлгээ нь банкны тухайн өдрийн хамгийн эхний гүйлгээ байна.
- ~~3.2 Монголбанкнаас 2 ажлын хөнгө болон түүнээс урт хугацаатай репо санхүүжилт олгох гүйлгээ нь хэлцэл байгуулсан одорт багтаан хийгдэх бөгөөд буцаан төлөх гүйлгээ нь буцаан төлөх өдрийн банкны хамгийн эхний гүйлгээ байна.~~
/Энэ заалтыг МБЕ-ийн 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А-281 дүгээр тушаалаар хүчингүй болгосон/
- 3.3 Репо хэлцлийн хүрээнд худалдах үнэ, буцаан худалдан авах үнэ нь төгрөг, мөнгөөр илэрхийлэгдэнэ.
- 3.4 Худалдах үнийг тооцохдоо тухайн үнэт цаасны зах зээлийн үнээс эрсдэлийн хямдруулалтыг хасна.
- 3.5 Репо санхүүжилтийн үнийн зөрүүг дараах томъёогоор тооцно:

$$P_d = P_p \times R_r \times \frac{d}{365}$$

P_d – Үнийн зөрүү

P_p – Худалдах үнэ

R_r – Репо санхүүжилтийн хүү (жилийн)

d – Репо санхүүжилтийн хугацаа

- 3.6 Репо санхүүжилтийн хэлцлээр Монголбанкны худалдан авах үнэт цаасны эзэмших эрх шилжих нөхцөл нь эрх зүйн хувьд бүрэн баталгаажсан байна.
- ~~3.7 Монголбанк тухайн үнэт цаасны дугаар, төрөл, тоо ширхэг, жилийн хүүгийн хувь, эзэмших хөнгөгийн тоо, худалдан авах өдөр, буцаан худалдан авах өдөр, худалдах үнэ, буцаан худалдан авах үнэ зэргийг тусгасан репо гэрээг энэ журмын 1.3-т заасан ерөнхий гэрээний дагуу хийнэ.~~

/Энэ заалтыг МБЕ-ийн 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А-281 дүгээр тушаалаар хүчингүй болгосон/

- 3.8 Гэрээнд заасан худалдах өдөр нь нийтээр амрах баярын өдөр, эсвэл долоо хоногийн амралтын өдрүүд байвал репо санхүүжилтийн хугацааг үргэлжилсэнд тооцож, хүүг хуанлийн хоногоор тооцно.
- 3.9 Репо санхүүжилтийн хэлцлийн гэрээний хугацаанд төлөгдөх купоны төлбөрийг худалдагч банк авах эрхтэй. Энэ нь зөвхөн купонтой үнэт цаасанд хамаарна.
- 3.10 Репо санхүүжилтийн хэлцлээр Монголбанкинд худалдах үнэт цаасны дуусах хугацаа нь буцаан худалдан авах өдрөөс хамгийн багадаа ажлын 3 өдрийн дараа байна.

Дөрөв. Репо санхүүжилтийн үйл ажиллагаа

- 4.1 Банк овернайт репо санхүүжилт авах хүсэлтээ Банк хоорондын цахим арилжааны систем (цаашид БХЦАС гэх)-ээр дамжуулан 17:00-17:10 цагийн хооронд Монголбанкны зах зээлийн үйл ажиллагаа хариуцсан газарт ирүүлнэ. БХЦАС-ээр ирүүлэх боломжгүй тохиолдолд факсаар, эсвэл албан бичгээр ирүүлнэ.

- ~~4.2 Банк ажлын 2 хоног болон түүнээс урт хугацаатай репо санхүүжилт авах хүсэлтээ БХЦАС-ээр дамжуулан 17:10 цагаас өмнө Монголбанкны зах зээлийн үйл ажиллагаа хариуцсан газарт ирүүлнэ. БХЦАС-ээр ирүүлэх боломжгүй тохиолдолд факсаар, эсвэл албан бичгээр ирүүлнэ.~~

/Энэ заалтыг МБЕ-ийн 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А-281 дүгээр тушаалаар хүчингүй болгосон/

- 4.3 Банк репо санхүүжилт авах хүсэлтээ БХЦАС-ээр ирүүлэх боломжгүй, энэ журмын 4.1-т дурдсанаар факсаар, эсвэл албан бичгээр ирүүлсэн тохиолдолд ерөнхий гэрээний хавсралтын дагуу репо гэрээг бичгэн хэлбэрээр байгуулж болно.

/Энэ заалтад МБЕ-ийн 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А-281 дүгээр тушаалаар өөрчлөлт оруулсан/

- ~~4.4 Ажлын 2 хоног болон түүнээс урт хугацаатай репо санхүүжилт авах хүсэлт ирүүлсэн банк энэхүү журмын 3.7-д заасан гэрээг репо санхүүжилт авах хүсэлт ирүүлснээс хойшхи дараагийн ажлын өдрийн 12:00 цагаас өмнө Монголбанкны зах зээлийн үйл ажиллагаа хариуцсан газарт холбогдох албан тушаалтны гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулан ирүүлнэ.~~

/Энэ заалтыг МБЕ-ийн 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А-281 дүгээр тушаалаар хүчингүй болгосон/

- ~~4.5 Энэхүү журмын 3.7-д заасан гэрээг банк энэхүү журмын 4.3-эхүл 4.4-т заасан хугацаанаас хоцроосон, эсхүл гэрээнд заасан зээлийн нөхцөл нь банкны БХЦАС-ээр ирүүлсэн хүсэлтээс зөрүүтэй байх тохиолдолд репо санхүүжилтийг үнийн~~

~~зөрүүний хамт банкны төв банк дахь харилцах данснаас буцаан толүүлэх хүртэл арга хэмжээ авч болно.~~

/Энэ заалтыг МБЕ-ийн 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А-281 дүгээр тушаалаар хүчингүй болгосон/

4.6 Монголбанк банкнаас ирүүлсэн репо санхүүжилтийн хүсэлтийн талаарх мэдээллийн нууцлалыг хадгална.

4.7 Монголбанк энэ журмын 4.1 бөхөн—4.2-д заасан хугацаанаас хойш ирсэн хүсэлтийг хүлээн авахгүй.

/Энэ заалтад МБЕ-ийн 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А-281 дүгээр тушаалаар өөрчлөлт оруулсан/

4.8 Банкны репо санхүүжилт авах хүсэлт нь дараах мэдээллийг агуулна:

4.8.1 Банкны нэр;

4.8.2 Репо санхүүжилт авах огноо;

4.8.3 Репо санхүүжилтийн хугацаа;

4.8.4 Репо санхүүжилтийн хэмжээ;

4.8.5 Худалдах үнэт цаасны мэдээлэл, тоо ширхэг;

4.8.6 Банкныг төлөөлөх эрх бүхий ажилтны гарын үсэг (хүсэлтийг факсаар, эсвэл бичгээр ирүүлэх тохиолдолд).

4.9 Банк репо санхүүжилт авах хүсэлтийг БХЦАС-д оруулан баталгаажуулсан тохиолдолд цуцлах эрхгүй.

4.10 Монголбанк БХЦАС-д баталгаажсан хүсэлтийг тухайн банкны албан ёсны хүчин төгөлдөр санал гэж үзнэ. Банкныг төлөөлөн БХЦАС-д нэвтэрч хүсэлт ирүүлэхтэй холбогдон гарч болзошгүй аливаа үйл ажиллагааны эрсдэлийг банк хариуцна.

4.11 Монголбанкны зах зээлийн үйл ажиллагаа хариуцсан газар банкны хүсэлтийг хянасны үндсэн дээр репо санхүүжилт олгох шийдвэрийг БХЦАС-ээр дамжуулан Монголбанкны төлбөр тооцоо хариуцсан газар 17:15 цагаас өмнө хүргүүлнэ.

4.12 Монголбанкны зах зээлийн үйл ажиллагаа хариуцсан газар банкны БХЦАС-д оруулсан саналыг баталж, Монголбанкны санхүү бүртгэл хариуцсан газарт дамжуулснаар Монголбанк, банк хооронд репо гэрээ байгуулсанд тооцно.

/Энэ заалтад МБЕ-ийн 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А-281 дүгээр тушаалаар өөрчлөлт оруулсан/

4.13 Монголбанкны санхүү бүртгэл хариуцсан газар репо санхүүжилтийг хэлцэл хийсэн өдөрт багтаан шилжүүлж, холбогдох санхүүгийн бүртгэлийг хийнэ.

/Энэ заалтад МБЕ-ийн 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А-281 дүгээр тушаалаар өөрчлөлт оруулсан/

- 4.14 Монголбанкны санхүү бүртгэл хариуцсан газар репо санхүүжилтийн хугацаа дуусах ажлын өдөр репо санхүүжилтийг үнийн зөрүүний хамт “Банксүлжээ” систем нээгдэхэд банкны харилцах данснаас төлүүлж, репо хэлцлээр худалдсан үнэт цаасыг банкны эзэмшилд шилжүүлнэ.
/Энэ заалтад МБЕ-ийн 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А-281 дүгээр тушаалаар өөрчлөлт оруулсан/

Тав. Репо санхүүжилтийн бүртгэл

- 5.1 Төв банкны репо санхүүжилтийн нягтлан бодох бүртгэлийг Монголбанкны л мөрдөж буй “Монголбанкны нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу хийнэ.
- 5.2 ~~Гэрээнд заасан~~ Худалдан авах өдөр Монголбанк худалдагч банкны дансанд худалдан авах үнийн дүнг шилжүүлэх, худалдагч банк эзэмшиж буй үнэт цаасаа Монголбанкинд шилжүүлэх гүйлгээ нэгэн зэрэг хийгдэнэ. Репо хэлцлийн гүйлгээ нэгэн зэрэг хийгдэх боломжгүй тохиолдолд репо хэлцэл хийсэн өдөрт багтаан хийнэ.
/Энэ заалтад МБЕ-ийн 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А-281 дүгээр тушаалаар өөрчлөлт оруулсан/
- 5.3 ~~Гэрээнд заасан~~ Буцаан худалдан авах өдөр худалдагч банк буцаан худалдан авах үнийг, Монголбанк үнэт цаасыг буцаан шилжүүлэх гүйлгээг нэгэн зэрэг хийгдсэнээр репо хэлцэл дуусгавар болно. Репо хэлцлийн гүйлгээ нэгэн зэрэг хийгдэх боломжгүй тохиолдолд буцаан худалдан авах өдөрт багтаан хийнэ.
/Энэ заалтад МБЕ-ийн 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А-281 дүгээр тушаалаар өөрчлөлт оруулсан/
- 5.4 Репо хэлцлээр хүлээсэн үүргийг аль нэг тал биелүүлээгүй тохиолдолд Монголбанк болон банкуудын хооронд байгуулсан ерөнхий гэрээнд заасан хариуцлагын арга хэмжээг авна.
/Энэ заалтад МБЕ-ийн 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А-281 дүгээр тушаалаар нэмэлт оруулсан/
- 5.5 Монголбанкны тайлан бүртгэл хариуцсан газар репо санхүүжилтийн үлдэгдлийг өдөр бүрийн “Банкуудтай хийх өглөг, авлагын тайлан”-д тусгана.

Зургаа. Бусад

- 6.1 Монголбанкны тайлан бүртгэл хариуцсан газар репо санхүүжилтийн үлдэгдлийг өдөр бүрийн “Банкуудтай хийх өглөг, авлагын тайлан”-д тусгана.
- 6.2 Энэ журмын заалттай холбоотой маргааныг талууд харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд нэгдсэн шийдвэрт эс хүрвэл Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

6.3 Энэ журмыг зөрчсөн этгээдэд Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

_____ооо_____